



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/17/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: <a href="mailto:Sunjidmaae@audit.gov.mn">Sunjidmaae@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Гэрчилгээ .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар



ЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.ЭРХЭМБАЯР ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 38  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Засаг даргын тамгын газрын даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цогт сумын Засаг даргын тамгын газрын даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Огтоно устгалын мөнгийг бэлнээр гаргасан боловч зарцуулаагүй, буцаан төвлөрүүлээгүй, төсвийн хэмнэлтийн горим зөрчсөн, малжуулалтыг гэрээний хугацаа дууссан хэдий ч дараагийн айлд шилжүүлээгүй зэрэг нь АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020132

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>255,225,181.00</b>	<b>263,927,331.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>50,000.00</b>	<b>0.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>255,175,181.00</b>	<b>263,927,331.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>47,810,180.00</b>	<b>56,562,330.00</b>
35410	Бичиг хэргийн материал	642,300.00	742,800.00
35420	Аж ахуйн материал	14,545,500.00	21,580,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,368,905.00	9,938,705.00
35440	Түлш, шатах тослох материал	7,132,000.00	4,178,750.00
35450	Барилгын засварын материал	13,565,942.00	13,565,942.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	6,555,533.00	6,555,533.00
35500	Биологийн хөрөнгө	0.00	0.00
35600	Мал амьтад	207,365,001.00	207,365,001.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>825,065,122.37</b>	<b>758,396,668.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>825,065,122.37</b>	<b>758,396,668.16</b>
39100	Газар	0.00	0.00
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>793,485,122.37</b>	<b>726,816,668.16</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	656,093,486.37	690,252,038.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-252,633,421.27	-317,921,176.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	164,550,105.00	153,970,105.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-133,772,452.18	-140,904,356.26
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	80,001,730.40	71,973,452.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-58,038,157.45	-57,218,842.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,991,954.00	36,570,604.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,314,765.29	-29,958,520.38
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	80,000,000.00	80,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	316,744,501.00	343,248,001.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-68,137,858.21	-103,194,637.33
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>31,580,000.00</b>	<b>31,580,000.00</b>
39301	Программ хангамж	1,240,000.00	1,240,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,240,000.00	-1,240,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33,045,000.00	33,045,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-1,465,000.00	-1,465,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,080,290,303.37</b>	<b>1,022,323,999.16</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>50,000.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>50,000.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>50,000.00</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	50,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,080,240,303.37</b>	<b>1,022,323,999.16</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,080,240,303.37</b>	<b>1,022,323,999.16</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,928,674.84	327,928,674.84
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>672,119,364.55</b>	<b>614,203,060.34</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	557,360,461.45	672,119,364.55

51220	Тайлант үеийн үр дүн	114,758,903.10	-57,916,304.21
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	80,192,263.98	80,192,263.98
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,080,290,303.37</b>	<b>1,022,323,999.16</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>596,500,424.75</b>	<b>485,669,390.71</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>202,540,814.80</b>	<b>73,367,053.71</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>202,540,814.80</b>	<b>73,367,053.71</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>202,540,814.80</b>	<b>73,367,053.71</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	202,540,814.80	73,367,053.71
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	0
120005	Түрээсийн орлого	0.00	0.00
141001	Хаагдсан данс	0.00	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>393,959,609.95</b>	<b>412,302,337.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,188,409.95</b>	<b>31,696,537.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,050,459.00	29,116,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,137,950.95	2,579,754.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>336,771,200.00</b>	<b>380,605,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	336,771,200.00	380,605,800.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>479,088,904.92</b>	<b>532,131,111.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>479,088,904.92</b>	<b>532,131,111.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>473,031,971.92</b>	<b>508,411,474.93</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,024,560.00</b>	<b>240,140,718.00</b>
210101	Үндсэн цалин	200,782,242.00	220,057,464.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,242,318.00	20,083,254.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,391,235.00</b>	<b>31,542,984.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,306,040.00	21,889,273.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,271,300.00	2,405,382.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,817,038.00	1,924,305.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,261.00	476,365.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,542,596.00	4,847,659.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>20,184,754.95</b>	<b>26,034,084.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,724,254.95	4,684,634.00
210302	Түлш, халаалт	14,460,500.00	21,349,450.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,469,400.00</b>	<b>26,587,264.00</b>
210401	Бичиг хэрэг	4,420,690.00	4,813,050.00
210402	Тээвэр, шатахуун	32,118,740.00	19,456,783.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,252,470.00	1,651,731.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	677,500.00	665,700.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>800,000.00</b>	<b>480,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	200,000.00	480,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,844,000.00</b>	<b>5,364,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,844,000.00	5,364,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,952,547.00</b>	<b>26,143,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,783,459.00	25,350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,888.00	375,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	69,800.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	81,400.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>109,365,474.97</b>	<b>152,119,424.93</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,174,400.00	33,345,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,191,074.97	118,773,524.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,056,933.00</b>	<b>23,719,637.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,556,933.00</b>	<b>22,719,637.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,593,633.00	21,391,853.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,963,300.00	1,327,784.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>117,411,519.83</b>	<b>-46,461,721.22</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,652,616.73</b>	<b>11,454,582.99</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,652,616.73	11,454,582.99
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>114,758,903.10</b>	<b>-57,916,304.21</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>393,959,609.95</b>	<b>412,302,337.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>393,959,609.95</b>	<b>412,302,337.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>57,188,409.95</b>	<b>31,696,537.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,050,459.00	29,116,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,137,950.95	2,579,754.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>336,771,200.00</b>	<b>380,605,800.00</b>

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	336,771,200.00	380,605,800.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>392,959,609.95</b>	<b>412,302,337.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>392,959,609.95</b>	<b>412,302,337.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>386,902,676.95</b>	<b>388,582,700.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>221,024,560.00</b>	<b>240,140,718.00</b>
210101	Үндсэн цалин	200,782,242.00	220,057,464.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,242,318.00	20,083,254.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,391,235.00</b>	<b>31,542,984.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,306,040.00	21,889,273.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,271,300.00	2,405,382.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,817,038.00	1,924,305.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,261.00	476,365.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,542,596.00	4,847,659.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,496,754.95</b>	<b>21,306,234.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,724,254.95	4,684,634.00
210302	Түлш, халаалт	19,772,500.00	16,621,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>42,911,719.00</b>	<b>28,675,364.00</b>
210401	Бичиг хэрэг	4,782,070.00	4,829,050.00
210402	Тээвэр, шатахуун	29,442,279.00	21,231,383.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,252,470.00	1,651,731.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,334,900.00	963,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>800,000.00</b>	<b>1,480,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	200,000.00	480,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,949,000.00</b>	<b>5,364,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	4,949,000.00	5,364,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>44,155,008.00</b>	<b>26,143,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,985,920.00	25,350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149,888.00	375,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	69,800.00	88,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	81,400.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,174,400.00</b>	<b>33,430,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,174,400.00	33,430,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,056,933.00</b>	<b>23,719,637.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,556,933.00</b>	<b>22,719,637.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,593,633.00	21,391,853.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,963,300.00	1,327,784.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,000,000.00</b>	<b>0.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,000,000.00	0.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,000,000.00</b>	<b>0.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.84	85,228,616.90	612,423,108.53	1,025,580,400.27
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-55,062,647.08	-55,062,647.08
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,928,674.84	85,228,616.90	557,360,461.45	970,517,753.19
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-5,036,352.92	0.00	-5,036,352.92
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол	0.00	0.00	0.00	0.00

	ашиг				
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	114,758,903.10	114,758,903.10
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	672,119,364.55	1,080,240,303.37
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	672,119,364.55	1,080,240,303.37
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,928,674.84	80,192,263.98	672,119,364.55	1,080,240,303.37
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-57,916,304.21	-57,916,304.21
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	<b>327,928,674.84</b>	<b>80,192,263.98</b>	<b>614,203,060.34</b>	<b>1,022,323,999.16</b>

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	380,605,800.00	359,213,947.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,605,800.00	359,213,947.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	379,605,800.00	358,213,947.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,127,000.00	239,705,118.00
210101	Үндсэн цалин	224,327,000.00	219,621,864.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,800,000.00	20,083,254.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,768,500.00	31,488,534.00
210201	Тэтгэврийн даатгал	25,784,500.00	21,834,823.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,246,000.00	2,405,382.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,796,800.00	1,924,305.00
210204	Ажилгүйдлийн даатгал	449,200.00	476,365.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,492,000.00	4,847,659.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,225,000.00	21,072,914.00
210301	Гэрэл, цахилгаан	4,600,000.00	4,451,314.00
210302	Түлш, халаалт	16,625,000.00	16,621,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,970,000.00	24,379,981.00
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,779,050.00
210402	Тээвэр, шатахуун	18,000,000.00	17,995,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,970,000.00	1,642,731.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	963,200.00
2105	Нормативт зардал	2,600,000.00	1,480,000.00
210502	Хоол, хүнс	500,000.00	480,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,100,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,600,000.00	5,364,000.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	6,600,000.00	5,364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,308,000.00	793,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	480,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	375,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,507,300.00	33,430,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,507,300.00	33,430,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	380,605,800.00	359,213,947.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	380,605,800.00	359,213,947.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>31,696,537.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>31,696,537.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>30,368,753.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>435,600.00</b>
210101	Үндсэн цалин		435,600.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>54,450.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		54,450.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>233,320.00</b>
210301	Гэрэл, цахилгаан		233,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>4,295,383.00</b>
210401	Бичиг хэрэг		1,050,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,236,383.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		9,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>25,350,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		25,350,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>1,327,784.00</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>1,327,784.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,327,784.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>31,696,537.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>31,696,537.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		29,116,783.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,579,754.00

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/38 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цогт сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нь цаг үеэ олсон, оновчтой зөвлөгөө, мэдээллээр ханган бүх талын дэмжлэг үзүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанарын өндөр түвшинд хүргэх чиг үүрэгтэй сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Хөдөлмөрийн тухай хууль тогтоомж болон бусад бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан ажиллах шаардлагатай байна. Иймд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цогт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 395.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 412.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цогт сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.7 хувиар буюу 66.6 сая төгрөгөөр буурсан

байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний ба эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 0.05 сая төгрөгийн бараа материалыг авлагыг бүрэн барагдуулсан байна.

Өглөгийн эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 263.9 сая төгрөг болж 8.7 сая төгрөгөөр өссөн нь түлш халаалтын зардал нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 52.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 9.8 мянган үнэ төлбөргүй хөрөнгө орлогоор тайлагнаж, үйл ажиллагаандаа 48.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 263.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 726.8 сая төгрөг болж буурсан нь Аймгийн ИТХ-ын 11 дүгээр тогтоолоор 12.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталсан, 33.0 сая төгрөгийн авто машиныг шилжүүлсэнтэй холбоотой

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,022.3 сая төгрөг болж -57.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 614.2 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 321.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 58.8 сая төгрөгөөр өсгөж, 380.6 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг улсын болон орон төсвөөс санхүүжүүлэхээр 380.6 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс нутгийн төсвөөс 380.6 сая төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 31.7 сая төгрөг, нийт 412.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 389.5 сая төгрөгийг зарцуулж, 22.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 359.2 сая төгрөг буюу 94.0 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар 31.7 сая төгрөгийн орлого хүлээн авч 25.0 сая төгрөгийг оготно устгалын зардлыг бэлэн авч одоогоор тодорхой ажил хийгдээгүй байна 5.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1.3 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 30 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг мэдээлээгүй байна. Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Төсвийн хэмнэлтийн талаар:**

Батлагдсан төсвийн зардлын 10%-ийг хэмнэж ажиллаагүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт, 22.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн хэмнэлт гаргаж ажиллах
2. Тээвэр шатахууны зардлын давтан үзэх
3. Гэрэл цахилгаан, шуудан холбооны зардлыг шууд зардлаар бичил хийхгүй байх

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 78.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 27.6 сая төгрөгийн зөрчлийг залруулан 25.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 25.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 27.6 сая төгрөгийн алдааг залрууллаа.

### **4.2 Төлбөрийн акт**

Хүнс хөдөө аж ахуйн газраас оготно устгалын зардал олгосон 25.0 сая төгрөгийн санхүүжилтийг бэлнээр гаргаж авсан бөгөөд ажил хийгдээгүй, буцаан төвлөрүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т/Батлагдсан төсвийг зориулалтын дагуу

ашиглах/16.5.2-т/батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.3 Албан шаардлага

Төсвийн хэмнэлтийн гормыг зөрчиж батлагдсан бүтэц орон тооноос 1 орон илүү ажиллуулан 7.1 сая төгрөгийн цалин олгосон, Засаг даргын нөөц хөрөнгөөс 16.2 сая төгрөгийг баяр ёслол, спортын уралдаан тэмцээний зардалд зарцуулсан нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2-т “шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх, 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх/ гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 134.6 сая төгрөгийн 30 мэдээллээс, 65.4 сая төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 44.0 сая төгрөгийн 5 мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Малжуулалтын гэрээний дагуу 3 толгой 2.4 сая төгрөгийн үхрийг дараагийн өрхөд шилжүүлээгүй, гэрээг сунгаагүй нь Малчинтай байгуулсан гэрээ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, гэсэн заалттай нийцэхгүй, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цогт сумын Засаг даргын тамгын газар	8	72.3	3	27.6	1	25.0	3	25.6		
5	Дүн	8	72.3	3	27.6	1	25.0	3	25.6		